



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

20 23 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 10/18

Даланзадгад сум

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.17 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас **ТОГТООХ** нь:


1. "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааны журам"-ыг нэгдүгээр, "Дуудлага худалдаа зохион байгуулах маяг"-ыг хоёрдугаар, "Худалдах, худалдан авах гэрээний маяг"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлага худалдааны журам батлах тухай" 193 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Дээрх журмыг хэрэгжүүлж ажиллахыг орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын дарга (захирал), эрхлэгч нарт даалгасугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Р.Сэддорж)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА



ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ЭД ХӨРӨНГИЙН ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эрх бүхий байгууллагаас шийдвэрлэсэн орон нутгийн өмчийн илүүдэлтэй буюу ашиглалтгүй байгаа, түүнчлэн ашиглах хугацаа дуусч элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн, ашиглах хугацаа нь дуусаагүй боловч осол гэмтэлд өртсөн зэргээс шалтгаалан цаашид сэргээн засварлаж албан хэрэгцээнд ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон үл хөдлөх болон хөдлөх үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдахад энэ журмыг мөрдөнө.

Хоёр. Дуудлагын худалдааны доод үнэ тогтоох

2.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх эд хөрөнгийн худалдах доод үнийг эзэмшигч байгууллагын саналыг үндэслэн Орон нутгийн өмчийн газар боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтооно.

2.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх хөрөнгийн худалдах доод үнийг хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар тогтоолгож, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлнэ.

2.3 Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгө 2 удаагийн дуудлага худалдаа амжилтгүй болсон тохиолдолд худалдах доод үнийг 30-50 хувиар үнэ бууруулан худалдах, эсхүл сэлбэгээр худалдах саналыг Орон нутгийн өмчийн газраас боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлнэ.

Гурав. Дэнчин

3.1 Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн худалдахаар санал болгох доод үнэ 10,000,000.00 (арван сая) хүртэл төгрөг бол дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 25 хувиар, 10,000,001.00 (арван сая нэг) төгрөгөөс 100,000,000.00 (нэг зуун сая) хүртэл төгрөг бол дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 20 хувиар, 100,000,001.00 (нэг зуун сая нэг) төгрөгөөс 1,000,000,000.00 (нэг тэрбум) төгрөг бол дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 15 хувиар, 1,000,000,001.00 (нэг тэрбум нэг) төгрөг болон түүнээс дээш бол дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 10 хувиар тус тус тогтооно.

3.2 Дэнчинг Орон нутгийн өмчийн газарт бэлнээр эсвэл шилжүүлгээр тушаана.

Дөрөв. Дуудлага худалдааны үнэ хаялцах хязгаарыг тогтоох

4.1 Дуудлагын худалдаагаар худалдах орон нутгийн өмчийн эд хөрөнгийн худалдахаар санал болгосон доод үнэ 1,000,000.00 (нэг сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 100,000.00 (нэг зуун мянга) төгрөгөөр, 1,000,001.00 (нэг сая нэг) төгрөгөөс 10,000,000.00 (арван сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 200,000.00 (хоёр зуун мянга) төгрөг, 10,000,001.00 (арван сая нэг) төгрөгөөс дээш бол үнэ хаялцах доод хязгаар 400,000.00 (дөрвөн зуун мянга) төгрөгөөр, дээд хязгаарыг худалдах доод үнэтэй уялдуулан дэнчингийн хэмжээ хүртэл байхаар тус тус тогтооно.

Тав. Дуудлага худалдааг зарлан мэдээлэх, оролцогч бүртгэх

5.1 Дуудлага худалдааг Орон нутгийн өмчийн газрын цахим хуудас болон өдөр тутмын сонинд нийтэлж, олон нийтэд хүргэнэ.

5.2 Оролцогчид “Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийн маягт”-ыг бөглөж, цаасаар бол дуудлага худалдаа болохоос 24 цагийн өмнө, цахимаар бол 48 цагийн өмнө бүртгүүлнэ.

5.3 Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг цахимаар бүртгүүлсэн оролцогчдын материалыг хянаж, шаардлага хангасан оролцогчдод дуудлага худалдаа болохоос 24 цагийн өмнө бүртгүүлсэн мэйл хаягаар дуудлага худалдаанд оролцох холбоос, нууц үгийг илгээнэ.

5.4 Цаасаар бүртгүүлсэн оролцогчид тогтоосон цаг, байршилд танхимаар, цахимаар бүртгүүлсэн оролцогчид бүртгүүлсэн мэйл хаягаар хүргүүлсэн холбоосоор нэвтэрч, цахим уулзалтын программаар оролцоно.

Зургаа. Дуудлага худалдааг зохион байгуулах

6.1 Дуудлагын худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар байгуулна.

6.2 Хөдлөх хөрөнгийн дуудлага худалдааг үнийн саналыг ээлж дараалан өсгөн үнэ хаялцах, үл хөдлөх хөрөнгийн дуудлага худалдааг худалдан авах үнийн дээд саналаа битүүмжлэн ирүүлэх зарчмаар зохион байгуулна.

6.3 Үнэ хаялцах дуудлага худалдаанд оролцогчид дараах үүрэгтэй.

6.3.1 Тогтоосон хугацаанд оролцогчид цахим уулзалтын программд нэвтрэх болон байршилд ирсэн байх

6.3.2 Цахимаар оролцож байгаа тохиолдолд өөрийн сүлжээ болон тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг бүрэн хариуцах

6.3.3 Оролцогчид бүртгүүлсэн дарааллаараа ээлжлэн үнийн санал хэлэх ба хамгийн багадаа 1 удаа үнийн саналыг хэлэх

6.4 Оролцогчоос үл шалтгаалах байдлаар дуудлага худалдааны үед техникийн саатал гарсан тохиолдолд дуудлага худалдааг дахин зохион байгуулна.

6.5 Битүүмжилсэн үнийн саналыг тогтоосон хугацаанд багтааж ирүүлэх бөгөөд хугацаа хоцорсон материалыг хүлээж авахгүй.

6.6 Битүүмжилсэн үнийн саналыг дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг оролцогчдыг байлцуулан ирүүлсэн дарааллаар задлан танилцуулж, хамгийн өндөр үнийн саналыг тодруулна.

6.7 Дуудлагын худалдааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 38-45 дугаар зүйлийг баримтлан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталсан маягтын дагуу хөтлөн явуулж, дуудлагын худалдааны ялагчтай “Худалдах, худалдан авах гэрээ”-г Орон нутгийн өмчийн газрын дарга байгуулна.

Долоо. Бусад

7.1 Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах шийдвэр гаргахаас өмнө тухайн хөрөнгийн эрхийн эзэмшил, ашиглалт, төлбөр тооцооны зөрчлийг тухайн хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллага бүрэн арилгасан байна.

7.2 Дуудлагын худалдаанд танхимаар оролцогч өөрийн биеэр оролцох боломжгүй бол итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож болно.

7.3 Орон нутгийн өмчит төсөвт байгууллагын эд хөрөнгийн дуудлагын худалдаанаас олсон орлогыг тухайн дуудлагын худалдааг зохион байгуулахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

7.4 Орон нутгийн өмчийн оролцоотой компани болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн дуудлагын худалдааны орлогыг хөрөнгийг сэргээн босгох, шинэчлэх зорилгоор тухайн байгууллагын дансанд төвлөрүүлэх эсэх асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

7.5 Дуудлага худалдааны ялагч худалдан авсан эд хөрөнгийн төлбөр /дэнчинг хассан дүнгээр/-ийг хуанлийн 14 хоногийн дотор төлөх бөгөөд төлөөгүй бол дэнчинг орон нутгийн төсвийн орлого болгож, худалдан авах эрх удаах үнийн санал гаргасан оролцогчид шилжинэ. Удаах оролцогч мөн худалдан авахаас татгалзвал дуудлага худалдааг дахин зарлан явуулна.



ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ МАЯГТ

Маягт-1

Дуудлага худалдааны зар мэдээ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20... оны ... дугаар тогтоолын дагуу
.....(худалдах эд хөрөнгийн нэр) хөрөнгийг
нээлттэй/хаалттай дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

1. Дуудлага худалдааны ерөнхий мэдээлэл

Дуудлагын худалдааны арга, хэлбэр	Нээлттэй/хаалттай, цахим/танхим, үнэ хаялцах/үнийн санал авах
Дуудлага худалдаа болох хугацаа	20... оны дугаар сарын....-ны өдрийн цагт
Дуудлага худалдаа болох газар	
Худалдах доод үнэ	Дуудлагаар худалдах хөрөнгийн нэр, худалдах доод үнэ (..... үсгээр) төгрөг
Дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ	Худалдах доод үнийн хувь буюу (үсгээр) төгрөг
Ялсан этгээдийг тогтоох журам	Үнэ хаялцсан ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна.
Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Гэрээг ажлын 3 хоногийн дотор байгуулна. Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг хуанлийн 14 хоногийн дотор төлнө.
Дэнчинг байршуулах хэлбэр, данс	☐ Бэлнээр: ☐ Шилжүүлгээр: Хүлээн авагч байгууллага: Дансны дугаар: Дансны нэр:

2. Дуудлага худалдаанд хүсэлт ирүүлэх, оролцогчийг бүртгэх

Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийн маягтыг зөв, цэвэр бөглөж, дэнчин төлснийг нотлох баримт, иргэний үнэмлэх (хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбарын хамт 20.... оны ... дугаар сарын-ны өдрийн цаг хүртэл
..... хуулийн этгээдийн (хаягийг тодорхой тусгана) байрны тоот
өрөөнд хүлээн авна. Цахим хүсэлтийг холбоосоор 20.... оны ... дугаар сарын-ны өдрийн
..... цаг хүртэл авна. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

3. Худалдах хөрөнгийн талаар мэдээлэл авах:

Дуудлагаар худалдах хөрөнгийг өмч эзэмшигч хуулийн этгээдийн
..... хаягаар очиж үзэж болох бөгөөд хөрөнгийн талаарх мэдээллийг
утсаар авна уу.

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ

1. Дуудлага худалдаагаар худалдах эд хөрөнгийг эзэмшигч.....
(хуулийн этгээдийн нэр)(хөрөнгийн нэр)
2. Оролцогчийн эцэг/эх/-ийн нэр, нэр:
3. Оролцогчийн регистрийн дугаар:
4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, нэр:
5. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн регистрийн дугаар:
6. Дэнчингийн хэмжээ(тоогоор) (үсгээр)
7. Дэнчинг тушаасанон сарөдөр цаг
8. Оролцогчийн оршин суугаа тодорхой хаяг:
- Харилцах утас
9. Хүсэлт бөглөсөн: он.....сар.....өдөр цаг
10. Дуудлагын худалдааны нөхцөл болон (эд хөрөнгийн нэр), эд хөрөнгөтэй танилцсан:
Гарын үсэг:.....

Жич: Дуудлагын худалдаанд оролцох бүрт энэ хүснэгтийг бөглөж, дэнчинг төлсөн баримтын 1 хувь, оролцогчийн иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргаж, дугтуйлж бүртгүүлнэ.

Хүсэлтэд бичигдсэн мэдээллийн үнэн зөв байдлыг оролцогч бүрэн хариуцах ба алдаатай, буруу бөглөсөн бол дуудлагын худалдаанд орох боломжгүй болохыг анхаарна уу.

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

20... оны ... сарын өдөр

1. Өмч эзэмшигч байгууллагын нэр

2. Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн нэр, марк, дугаар, тоо хэмжээ:

.....

3. Дуудлага худалдааны зар мэдээлэл гаргасан телевиз, сонин сэтгүүлийн нэр он, сар, өдөр:

4. Дуудлагын худалдаа явагдсан газар он, сар, өдөр, цаг, минут:

.....

5. Дуудлагын худалдааны доод үнэ: (тоогоор) (үсгээр) төгрөг.

6. Дэнчингийн хэмжээ:(тоогоор) (үсгээр) төгрөг.

Тусгай тэмдэглэл:

.....

7. Дуудлага худалдаанд оролцогчдын нэр:

Оролцогчдын нэр

Пайзны дугаар

1.

.....

2.

.....

3.

.....

4.

.....

8. Ажиглагчдын нэрс

1.

2.

3.

9.Нэмэлт тэмдэглэл

Явцын тусгай тэмдэглэл

10.Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулсан:

1. Ажлын хэсгийн дарга

2. Хөтлөгч

4. Тэмдэглэл хөтлөгч.....

Хөтлөгч дуудлагын худалдааны журмыг танилцуулж, дуудлагын худалдаа эхэлснийг зарлав. Өсгөн нэмэгдүүлэх үнийн доод хязгаар (тоогоор) (үсгээр) төгрөг, дээд хязгаар (тоогоор), (үсгээр) төгрөг, болохыг танилцуулав.

Дуудлагын худалдаа дараах байдалтай явагдав.

№	Пайзны дугаар	Үнийн санал

№	Пайзны дугаар	Үнийн санал

№	Пайзны дугаар	Үнийн санал

Дуудлагын худалдааны эцсийн үнэ төгрөг.....мөнгө
..... (үсгээр)

Удаах оролцогчийн эцсийн үнийн санал төгрөгмөнгө
..... (үсгээр)

Дуудлагын худалдаанд ялагчийн эцэг/эх/-ийн нэр, нэр:

Оршин суугаа хаяг, харилцах утас:

Удаах оролцогчийн эцэг/эх/-ийн нэр:

Оршин суугаа хаяг, харилцах утас.....

Дуудлагын худалдааны тэмдэглэлтэй танилцсан:

Ажлын хэсгийн дарга /...../

Хөтлөгч /...../

Тэмдэглэл хөтлөгч: /...../

Дуудлагын худалдаанд оролцогчийн нэр, гарын үсэг:

1. /...../

2. /...../

3. /...../

4. /...../

5. /...../



“ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ” ГЭРЭЭНИЙ МАЯГТ

20...оны...сарын...-ны...өдөр

Дугаар...

(аймаг, сум)

Энэхүү гэрээг нэг талаас (Орон нутгийн өмчийн газар, эсхүл өмч эзэмшигч хуулийн этгээд), түүнийг төлөөлж, (цаашид “худалдагч” гэх), нөгөө талаас дуудлагын худалдааны ялагч болсон иргэн /эсхүл хуулийн этгээд/ (нэр) (регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар) (цаашид “худалдан авагч”, хамтад нь “талууд” гэх) нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 197.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох эрх зүйн актад заасан дуудлагын худалдааны журмыг үндэслэн байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэрээний зорилго: Худалдагч гэрээнд заасан эрхийн зөрчилгүй /эд хөрөнгийн нэр, марк, төрөл/ (цаашид “эд хөрөнгө” гэх)-ыг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь дуудлага худалдааны журам, гэрээнд дурдсан нөхцөлөөр үнийг төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний зүйл: Худалдах, худалдан авах эд хөрөнгө нь “.....” орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, улсад онд үйлдвэрлэгдсэн /нийт жил ашигласан/, “.....” маркийн..... өнгөтэй,.....

..... /техникийн үзүүлэлт/ байна. Энд худалдах үеийн хөрөнгийн бодит байдал, техникийн болон шаардлагатай үзүүлэлтийг нэмж оруулна. Шаардлагатай бол гэрээний зүйлийн үзүүлэлтийг тусгасан хавсралт үйлдэнэ.

1.3 Энэ гэрээ нь албан ёсоор байгуулагдсан өдрөөс эхлэн гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелэх хүртэл хугацаанд үйлчилнэ.

Хоёр. Эд хөрөнгийг шилжүүлэх

2.1 Худалдан авагч эд хөрөнгийн төлбөрийг гэрээнд заасны дагуу бүрэн төлснөөр өмчлөх эрхтэй болно.

2.2 Гэрээний зүйл нь эрхийн зөрчилгүй байна. Эрхийн зөрчилгүй гэдэгт гуравдагч этгээд өөрийн эдлэх эрхийн талаар ямарваа нэгэн гомдлын шаардлага гаргахгүй байхыг ойлгоно.

2.3 Худалдагч худалдан авсан эд хөрөнгийн холбогдох баримт, бичгийг төлбөр бүрэн төлөгдөж, гэрээнд заасан холбогдох дансанд орсноос хойш ажлын 5 өдрийн дотор эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авч шилжүүлнэ. Эд хөрөнгийг эрх шилжүүлэх зөвшөөрөл гармагч хүлээлгэн өгнө. Хөрөнгө хүлээлцэх актыг 2 хувь үйлдэж талууд тус бүр 1 хувийг авна.

2.4 Дуудлагаар худалдсан эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдон гарах үйлчилгээний хураамж болон бусад зардлыг худалдан авагч хариуцна.

2.5 Худалдсан эд хөрөнгийг худалдан авагчид хүлээлгэн өгөхөөс өмнөх хугацааны татвар, хураамж, даатгалтай холбоотой зардлыг худалдагч бүрэн хариуцна.

Гурав. Төлбөр тооцоо

3.1 Энэхүү гэрээний 1.2-т заасан эд хөрөнгийн нийт үнэ (тоогоор)
..... (үсгээр) төгрөг.

3.2 Энэхүү гэрээний 3.1-д заасан үнэ нь дуудлага худалдаанд оролцож ялсан үнэ болно.

3.3 Эд хөрөнгийн зах зээлийн үнэ, валютын ханш өөрчлөгдөх нь энэхүү гэрээний 3.1-д заасан үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

3.4. Худалдан авагч нь дэнчин болгон нийт (тоогоор)
..... (үсгээр) төгрөгийг
тушаасан бөгөөд дэнчин нь энэхүү гэрээний 3.1-д заасан үнэд тооцогдоно.

3.5. Худалдан авагч нь гэрээ албан ёсоор байгуулагдсанаас хойш хуанлийн 14 хоногийн дотор үлдэгдэл төлбөр болох (тоогоор)
..... (үсгээр) төгрөгийг худалдагч
..... (хуулийн этгээдийн нэр)-ийн (банк, дансны нэр), тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг

4.1 Худалдагчийн эрх, үүрэг:

А) Худалдагч нь худалдан авагчид эрхийн доголдолгүй эд хөрөнгийг гэрээнд заасны дагуу хүлээлгэн өгөх үүрэгтэй.

Б) Эд хөрөнгийн үнийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг худалдан авагчаас шаардах эрхтэй.

В) Худалдан авагч худалдан авсан эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол дэнчинг улсын орлогод авч, гэрээг дангаар цуцлах эрхтэй.

Г) Гэрээний үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй.

4.2 Худалдан авагчийн эрх, үүрэг:

А) Гэрээнд заасны дагуу эрхийн доголдолгүй эд хөрөнгийг актаар хүлээн авах эрхтэй.

Б) Эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.

В) Худалдан авсан эд хөрөнгийн үнийг бүрэн төлснөөр эд хөрөнгө, өмчлөх эрхийг шилжүүлэн авах болон холбогдох баримтыг шаардах эрхтэй.

Г) Эд хөрөнгийг хүлээлцэхээр тогтоосон хугацаанд хүлээн аваагүй тохиолдолд тухайн эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, арчлахтай холбогдон гарах зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Д) Гэрээний үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй.

Тав. Талуудын хариуцлага

5.1 Энэ гэрээний нөхцөлийг зөрчсөн буруутай тал түүнээс болж нөгөө талд учирсан бүх хохирол, алдагдлыг үл маргах журмаар төлнө.

5.2 Худалдан авагч эд хөрөнгийн үнийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол худалдаж авах эрхээ алдана.

5.3 Худалдан авагч эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол дэнчинг нэхэмжлэх эрхээ алдах ба энэхүү гэрээг худалдагчийн санаачлагаар цуцлах үндэслэл болно.

5.4 Худалдан авагч нь тогтоосон хугацаанд эд хөрөнгийг хүлээн аваагүй тохиолдолд эд хөрөнгө хүлээлцэхээр тогтоосон өдрөөс хойшхи гэмтэл, доголдлыг худалдагч хариуцахгүй болно.

Зургаа. Маргааныг шийдвэрлэх

6.1 Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

6.2 Хэрэв харилцан тохиролцох боломжгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

7.1 Талууд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн эрсдэлийг бие даан хариуцах бөгөөд үүнтэй холбоотой аливаа асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.2 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн эргэлт, террорист үйлдэл, иргэдийн үймээн, бослого, нийтийн эмх замбараагүй байдал)-ийн улмаас биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөлийг арилах хүртэл хойшлуулж болно.

7.3 Энэхүү гэрээний үүргийн биелэлтэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нөгөө талдаа яаралтай мэдэгдэнэ.

7.4 Шаардлагатай бол төрийн эрх бүхий байгууллагын баримт нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл мөн байсан болон түүний үргэлжилсэн хугацааны нотолгоо болно.

Найм. Бусад нөхцөл

8.1 Энэ гэрээ нь хавсралтын хамт нийт..... хуудас, үндсэн эхийг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр 1 хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

8.2 Талууд энэ гэрээнд дурдаагүй бусад асуудлыг шийдвэрлэхэд холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН

АЛБАН ТУШААЛТАН /...../

/ЭСВЭЛ ӨМЧ ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГА/

УТАС.....

ХАЯГ.....

И-МЭЙЛ ХАЯГ.....

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,

ИРГЭН..... /...../

РЕГИСТРИЙН ДУГААР.....

УТАС.....

ХАЯГ.....

И-МЭЙЛ ХАЯГ.....